

**“ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО
БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ЭЦСИЙН
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2015 оны 06 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Г. Баярсайхан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг Улсын Их Хурлын 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг 2015 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах танилцуулгыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

1. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр гишүүдийн олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг төсөлд нэмж тусган, үг хэллэг, дэс дарааллын зарим засвар хийж, төслийн эцсийн хувилбарыг бэлтгэлээ.

2. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт хураалгах зарчмын зөрүүтэй саналын томъёолол Байнгын хорооны гишүүдээс гараагүй.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусгасан төслийн эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА**



Д. БАТЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого” /2015-2030/-ыг хавсралтаар баталсугай.

2.“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /*Ч.Сайханбилэгт*/-т даалгасугай:

1/“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын зөрилт *зорилго*, зарчимд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, *Монгол* Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-д тусгасан зөрилт *зорилго*, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нийгмийн даатгалын сангийн болон улсын төсөвт тусгуулах, арга хэмжээний төлөвлөгөөг батлан тус тус хэрэгжүүлэх.

3.“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг *Монгол* Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /*Д.Батцогт*/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО /2015-2030/

НЭГ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА

~~Монгол Улс 1990-ээд оны эхээр зах зээлийн эдийн засгийн баримжаатай чөлөөт, ардчилсан нийгэмд шилжиж, улс төр, нийгэм, эдийн засгийн бүх түвшинд өөрчлөлт, шинэчлэлт хийсний нэг нь бүх нийтийг хамарсан, тэгшитгэн хуваарилах шинжтэй, улсын төсвөөс санхүүжүүлж байсан тэтгэвэр, тэтгэмжийн хуучин тогтолцоог өөрчлөн шимтгэлд суурилсан, шимтгэлийн орлогоороо тэтгэвэр, тэтгэмжийн зардлаа нөхдөг хуваарилалтын санхүүжилттэй нийгмийн даатгалын тогтолцоог шинээр нэвтрүүлсэн явдал юм.~~

~~Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан багц хуулийг УИХ-аас 1994 онд баталж, 1995-оноос тэтгэврийн даатгалын тогтолцоог нэвтрүүлснээс хойш тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, шимтгэл хураалтыг сайжруулах, сангийн чадавхийг бэхжүүлэх, тэтгэврийн хэмжээг зохистой түвшинд хүргэх бодлогыг хэрэгжүүлж ирсэн. Тэтгэврийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчийн тоо 2000 онд 13,0 мянга байсан бол 2013 онд 35,5 мянган ажил олгогч болж, 2,7 дахин нэмэгдэн, даатгуулагчийн тоо 2000 оны түвшингээс 1,9 дахин өсч 952,4 мянга болжээ. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жил ба түүнээс дээш жил төлсөн даатгуулагчид хуульд заасан насны болзол хангасан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй байдаг. Харин тэтгэврийн хэмжээг тогтооходоо 20 жилийн 45 хувиар, түүнээс дээш шимтгэл төлсөн жил тутамд 1,5 хувиар тооцож нэмэгдүүлдэг. 2014 оны байдлаар нийт өндөр насны тэтгэвэр авагчдын тоо 248,6 мянга хүрсэн байна.~~

~~Ирээдүйд бий болох хүн ам зүйн ачааллын өсөлт, насжилтын угтаж тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчлэх зорилтыг дэвшүүлж, УИХ-аас 1999 онд "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл" болон "Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль" ийг баталж, тэтгэврийн шинэчлэлийн талаар дунд, урт хугацаанд мөрдөн ажиллах бодлогыг төдөрхөйлсөн юм.~~

~~Уг бодлогын баримт бичиг даатгуулагч төлсөн шимтгэлийн хэмжээтэйгээ уялдаатай тэтгэвэр авах, тэтгэврийн санг үнэгүйдлээс хамгаалан хөрөнгө оруулалтад хийх зарчмаар өсгөн арвижуулах, 1960-оноос хойш төрсөн иргэдийн хуваарилалтын санхүүжилттэй тэтгэврийн тогтолцоог хийсвэр нэрийн дансны тогтолцоонд шилжүүлж, бодит хагас хуримтлалын тогтолцоонд 2005-оноос эхлэн үе шаттайгаар, бүрэн хуримтлалын тогтолцоонд 2021-оноос хойш тус тус шилжүүлэх зорилт дэвшүүлсэн юм. Уг зорилтын дагуу Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийг УИХ-аас баталж, 1960-оноос хойш төрсөн даатгуулагчид хийсвэр нэрийн данс нээж, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн хэмжээг сар бүрээр бүртгэж, бичилт хийх болсон.~~

~~Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд тэтгэврийн сангийн орлогыг санхүүгийн хөрөнгө оруулалтад хийж тухай заалт тусгагдаагүй бөгөөд сангийн шимтгэлийн орлогоор иргэдийн тэтгэврийн зардлыг санхүүжүүлж ирсэн. Түүнчлэн нэрийн дансны даатгуулагчийн ирээдүйд авах тэтгэврийн хэмжээ нь тэтгэврийн санг хөрөнгө оруулалтад хийсэн өгөөжөөс шалтгаалахгүй байхаар өндөр насны тэтгэвэр бөдөх томьёогтодорхойлсон байна.~~

~~Бөдлогын баримт бичигт тусгагдсан тэтгэврийн тогтолцоог хагас журимтлалын тогтолцоонд шилжих зорилтыг хангах шинэчлэлийн арга хэмжээг өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлээгүй бөгөөд ингэх санхүү, хөрөнгийн зах зээлийн урьдчилсан нөхцөл хангагдаагүй, тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг 5 пунктээр бууруулж 14 хувь болгосон, тэтгэврийн хэмжээг үнэ, ханш, инфляцийн түвшиний өөрчлөлтөөр бус санхүүгийн бөлөлцөөнд үндэслэн үе үе нэмэгдүүлсэн, тэтгэврийн нас, тэтгэвэр бөдөх томьёо зэрэг параметрийг өөрчлөөгүй зэргээс шалтгаалан тэтгэврийн даатгалын сангийн алдагдал жил бүр өсч, түүнийг нөхөх улсын төсвийн ачаалал нэмэгдсээр байна.~~

~~Тэтгэврийн даатгалын сангийн зарлага 2011 онд ДНБ-ний 4.1 хувь байсан бол 2013 онд 370.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, ДНБ-ний 5.7 хувь болж, санд улсын төсвөөс олгох татаасийн хэмжээ 264,5 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 1.4 хувь болов. Тэтгэврийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх замаар алдагдалгүй болгохын тулд шимтгэлийн хэмжээг 14 хувиас өсгөх шаардлагатай байна.~~

~~Цаашид тэтгэврийн тогтолцоонд өөрчлөлт хийхгүй тохиолдолд тэтгэврийн сангийн алдагдал урт хугацаанд ДНБ-ний 12 хувьд¹ хүрэх тооцоотой байна. Үүнд хүн амын насжилт, түүнээс улбаалсан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, тэтгэврийн нас, тэтгэвэр бөдөх хувь хэмжээний зохистой харьцаа алдагдаж явдал нөлөөлж байна.~~

~~Дундаж наслалт нэмэгдснээр нийт хүн амд эзлэх тэтгэвэр авагчдын тоо өсч, 10 даатгуулагчид нөгдөх тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2013 онд 4, 2030 он гэхэд 7, цаашид 9 тэтгэвэр авагч болохоор байна.~~

~~Хүн амын дундаж наслалт 2013 онд 69,1 жил болж, 2000 оны дундажтай харьцуулахад 5,9 жилээр өссөн бөгөөд эрэгтэйчүүдийн дундаж наслалт 65,4 жил байхад эмэгтэйчүүдийнх 75,0 жил байна.~~

~~60 насандаа 2013 онд тэтгэвэрт гарсан эрэгтэй хүн дунджаар 15 жил тэтгэвэр авах бол, энэ хугацаа 2020 онд 15.8 жил, 2030 онд 16.2 жил болох бөгөөд 55 настайдаа 2013 онд тэтгэвэрт гарсан эмэгтэй хүн 23 жил тэтгэвэр авах бол, цаашид энэ хугацаа 2020 онд 23.5 жил, 2030 онд 24.6² жил болж тус тус уртасаж хэтийн тооцоотой байна.~~

~~Харин тэтгэвэр авагчийн шимтгэл төлсөн дундаж хугацаа 2013 онд эрэгтэй даатгуулагчийн хувьд дунджаар 25.6 жил, эмэгтэй даатгуулагчийн хувьд 26.1 жил байна. Иймээс эмэгтэй даатгуулагчийн хувьд 26 жил шимтгэл төлөөд 23 жил~~

1

~~PROST загвараархийсэнхэтийнтооцоолол, ДБ-ны зөвлөх Назир Вайнд, 2014 он~~

2

~~Хүн амын 2010-2040 оны хэтийн тооцоо, Үндэсний Статистикийн хөрөө~~

~~тэтгэвэр авах нь түүний амьдралын идэвхитэй насны үеийг идэвхигүй үеийн хугацаатай бараг ойролцоо болгож тэтгэврийн даатгалын сангийн зарлагад ачаалал үзүүлэхээр байна. Энэ нь хүн ам зүйн хүчин зүйлтэй уялдуулан тэтгэврийн нас, шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөхгүй тохиолдолд тэтгэврийн сангийн алдагдал хурдацтай өсөхийг нотолж байна.~~

~~“Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль”-ийн дагуу 2012 оны байдлаар 1.1 сая даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээж 6.9 их наяд төгрөгийн шимтгэлийг хийсвэрээр бүртгэсэн боловч эдгээр даатгуулагчийн 73 хувь нь 5-аас доош жил шимтгэл төлжээ.~~

~~1960 онд төрсөн эмэгтэй даатгуулагч 2015 оноос эхлэн “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль”-иар өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй бөгөөд түүний тэтгэврийн хэмжээ нь 1960 оноос өмнө төрсөн даатгуулагчид үйлчлэх Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай 1994 оны хуулийн дагуу тогтоогдох өндөр насны тэтгэврийн хэмжээнээс хэт бага байх тооцоо гарч байна.~~

~~Энэ нь адил хугацаанд, ижил цалингаас шимтгэл төлсөн ойролцоо насны даатгуулагчдын тэтгэврийн хэмжээ илт зөрүүтэй тогтоогдож, нийгмийн шударга бус хуваарилалтыг бий болгох нөхцөлийг үүсгэнэ. Иймд Монгол Улсын нийт ахмад настанд тэгш хандаж, төлсөн шимтгэлийн хэмжээтэйгээ уялдаатай, амьжиргааг хангахуйц хэмжээний тэтгэвэр авах ижил бололцоогоор хангах нь зүйтэй юм.~~

~~Түүнчлэн малчид, бага орлоготой хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчид тэтгэврийн даатгалд сайн дураар даатгуулах эрх зүйн орчин нээлттэй хэдий ч өнөөгийн тогтолцоо тэдний хөдөлмөрийн болон орлогын хэв шинжтэй нийцээгүй, ажил олгогчийн дэмжлэггүй бие даан шимтгэл төлөхөд зардал өндөр байгаагаас хөдөлмөрийн насны 261.7 мянган малчдын дөнгөж 9,1 хувь нь тэтгэврийн даатгалтай байна.~~

~~Иймд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчдад зориулсан тэтгэврийн даатгалын тусгай хөтөлбөрийг нэвтрүүлж, тэднийг тэтгэврийн орлогын баталгаагаар хангаж, улмаар халамжийн сангийн ирээдүйн зардлыг бууруулах шаардлагатай байна.~~

~~Сүүлийн жилүүдэд уул уурхай, эрдэс баялаг, барилга зэрэг эрчимтэй өсөлттэй салбарын болон хөдөлмөрийн зах зээл дэх үр чадвартай ажилтны цалин хөлс нь улсын дунджаас хэд дахин өндөр болж, ирээдүйн орлогын баталгаагаа нэмэгдүүлэх зорилгоор тэтгэврийн нэмэлт даатгалд даатгуулах эрэлт хэрэгцээ үүсч байна.~~

~~Монгол Улсад хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын үйл ажиллагааг цөөн тооны банк, санхүүгийн байгууллага ажилтнуудаа тогтвор, суурьшилтай ажиллуулах хөшүүрэг болгон нэвтрүүлж эхэлсэн ч хүртээмж хязгаарлагдмал байна. Цаашид өндөр орлоготой даатгуулагчийн тэтгэврийн хувийн нэмэлт даатгалд даатгуулах эрхийг баталгаажуулж, хувийн тэтгэврийн сангийн хэрилцааг зохицуулах, эрсдлээс хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.~~

~~Дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор, хүн амын насны бүтэц харьцангуй тааламжтай байх үед тэтгэврийн тогтолцоог шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настанд зохистой хэмжээний тэтгэврийг урт хугацаанд тогтвортой олгох нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн шударга хуваарилалтыг баталгаажуулах, тэтгэврийн даатгалд хамрах хүрээг өргөжүүлж малчид, албан бус салбарт ажиллагчдыг тэтгэврийн орлоготой болгох, тэтгэврийн сангийн алдагдлыг бууруулж, тэтгэврийн даатгалын шимтгэл, тэтгэврийн нас, тэтгэвэр бодох аргачлалыг өнөөчтэй тогтоох шаардлагыг иш үндэс болгон "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого (2015-2030)"-ыг шинэчлэн бөлөвөрүүлэв.~~

~~ХОЁР. ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЗОРИЛГО~~

Нэг.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зорилго

1.1.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын насны бүтцийн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, ажил олгогч, иргэн санхүүгийн чадавхидаа чадавхт үндэслэн хамтран хариуцаж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

1.2.Тэтгэврийн шинэчлэлийн бодлого нь тэтгэврийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зориулсан тусгай хөтөлбөрийг бий болгож, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин, ахмад настан олон өж үүевэрээ эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулна.

~~ГУРАВ.ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЗАРЧИМУУД~~

Хоёр.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зарчим

2.1.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1.Монгол Улсын ахмад настан бүр орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангагдах;

2.1.2.иргэн бүр хөдөлмөрийн чадвартай үедээ тэтгэврийн даатгалд хамрагдаж, өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрхтэй байх;

2.1.3.өндөр насны тэтгэврийн хэмжээ нь даатгуулагчийн авч байсан цалин хөлс, төлсөн шимтгэлийн хэмжээ, хугацаатай уялдаатай шударга байх;

2.1.4.эрэгтэй, эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаар ижил байх;

2.1.5.тэтгэврийн даатгалын сангийн зардлыг төр, иргэн, ажил олгогч хамтран хариуцна хариуцах;

2.1.6.тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлагыг тэнцвэржүүлж, сангийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас хэтрүүлэхгүй байх;

2.1.7.хөдөлмөрийн бүтээмж өндөртэй даатгуулагчийг нэмэлт хуримтлал, хадгаламж үүсгэх замаар өндөр насны ~~тэтгэврийн~~ тэтгэвэр тогтоолгох үед санхүүгийн олон ~~эх үүсвэрээ~~ эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой болох нөхцөлийг хангаж, орлогын баталгааг нь нэмэгдүүлэх;

2.1.8.иргэний насан туршдаа суралцах, хөгжих нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй хөдөлмөрлөхийг дэмжин ахимаг насны ~~иргэдэд~~ иргэнд тохирсон ажлын байр бий болгохыг урамшуулах.

ДӨРӨВ. ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЧИГЛЭЛ

Гурав. Тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын чиглэл

3.1.Тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1.хөдөлмөрийн гэрээ, түүнтэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос ~~бүх ажилтан, төрийн албан хаагч албан хаагчид~~ тэтгэврийн даатгалд заавал шимтгэл төлж даатгуулах;

3.1.2.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус салбарт ажиллагч бага орлоготой ~~иргэдэд~~ иргэнд зориулсан албан журмын тэтгэврийн даатгалын тусгай хөтөлбөр бий болгох;

3.1.3.тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх орлогын дээд хязгаараас давсан өндөр орлоготой даатгуулагч хувийн-~~жөвшлийн~~ тэтгэврийн нэмэлт даатгалд сайн дурын үндсэн дээр даатгуулах нөхцөлийг бүрдүүлэх.

3.2.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1.тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх үүсээгүй, амьжиргааны түвшин доогуур, орлогогүй ахмад настанд нийгмийн халамжийн тэтгэвэр олгох;

3.2.2.1960 оноос өмнө төрсөн ~~иргэдэд~~ иргэнд үйлчлэх эв санааны зарчимд үндэслэх тэтгэврийн даатгалын хуваарилалтын одоогийн тогтолцоог үргэлжлүүлэн мөрдөж, энэ тогтолцоонд параметрийн шинэчлэл хийх замаар тэтгэврийн сангийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах;

3.2.3.энэ **заалтын** 3.2.2-т заасан тогтолцооны хүрээнд олгох

тэтгэврийн хэмжээг даатгуулагчийн авч байсан цалин хөлс, шимтгэл төлсөн хугацаанд үндэслэн тогтоох;

3.2.4.1960 оноос 1979 оны хооронд төрсөн даатгуулагчид цалин хөлс, шимтгэл төлсөн хугацаанд суурилсан тогтолцоо **болон** шимтгэлийн хийсвэр нэрийн дансны тогтолцоо /цаашид “нэрийн дансны тогтолцоо” гэх/-ны аль таатай нөхцөлөөр тэтгэврээ тогтоолгох сонголт олгох;

3.2.5.1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийг нэрийн дансны тогтолцоонд үндэслэн тогтоох **бөгөөд** энэ тохиолдолд тэтгэврийн хэмжээг тэнцвэртэй байлгах зарчмыг баримтлан холбогдох хуульд тухайн үед нь өөрчлөлт өрүүлж бөлнө оруулах;

3.2.6. даатгуулагч тэтгэвэр тогтоолгох насны хязгаарыг жангаж хязгаарт хүрч, 10 ба түүнээс дээш жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол өндөр насны тэтгэвэр авах эрхтэй **байх**;

3.2.7.1979 оноос өмнө төрсөн даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн хэмжээ нь ажилласан жил тутамд дундаж цалин хөлсний 2 хувиас багагүй байхаар бодож тогтоох;

3.2.8.1979 оноос өмнө төрсөн даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагчийн 5 жилийн цалин хөлсний дунджаар тодорхойлж байгааг 2020 оноос нэмэгдүүлж, 2025 он гэхэд даатгуулагчийн 10 жилийн цалин хөлсний дундажид үндэслэн тодорхойлдог болох **бөгөөд** цаашид даатгуулагчийн шимтгэл төлсөн нийт хугацааны цалин хөлсний дундажид үндэслэн тэтгэврийг тогтоох;

3.2.9.1960 ба 1979 оноос өмнө төрсөн даатгуулагч бүрт тэтгэврийн баталгаат хэмжээнээс багагүй тэтгэвэр тогтоож олгох **бөгөөд** тэтгэврийн баталгаат хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшин, улсын дундаж цалин хөлстэй уялдуулан Засгийн газраас Засгийн газар жил бүр төгтөөнө тогтоох;

~~3.2.10.1979 оноос хойш төрсөн даатгуулагч, ахмад настан бүрт нийгмийн суурь тэтгэвэр олгож, нийгмийн халамжийн тэтгэврийг нийгмийн суурь тэтгэврээр орлуулах. Нийгмийн суурь тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшинтэй уялдуулан Засгийн газраас тогтооно. Нийгмийн суурь тэтгэврийн зардлыг улсын төсвөөс хариуцан санхүүжүүлнэ;~~

3.2.10.тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн ахмад настан бүрт суурь тэтгэвэр олгоно. Суурь тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшинтэй уялдуулан Засгийн газраас жил бүр тогтоох бөгөөд суурь тэтгэврийн зардлыг тэтгэврийн даатгалын сан болон улсын төсвөөс хариуцан санхүүжүүлэх;

3.2.11.1979 оноос хойш төрсөн иргэдэд иргэнд үйлчлэх нэрийн дансны тогтолцоо нь шимтгэлийн орлогоороо тэтгэврийн зардлаа нөхдөг хуваарилалтын санхүүжилттэй байх;

3.2.12. нэрийн дансны тогтолцооноос олгох өндөр насны тэтгэврийн хэмжээг даатгуулагчийн төлсөн нийт шимтгэлийн хэмжээ, түүнд бодсон хийсвэр хүү, тэтгэвэр авах хугацааны дундаж илэрхийлэлд үндэслэн тогтоох;

3.2.13. нэрийн дансны тогтолцооноос олгох хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр бодох аргачлалыг шинэчилж, тэтгэврийг даатгуулагчийн цалин хөлс болон шимтгэлтэй уялдаатай бүхий бүрэлдэхүүн хэсэг уялдаатай байхаар өөрчлөх;

~~3.2.14. эдийн засаг, санхүү, хөрөнгийн зах зээлийн урьдчилсан нөхцөл хангагдвал нэрийн дансны тогтолцоонд даатгуулагчийн төлсөн шимтгэлийг хэсэгчлэн бодит хөрөнгө оруулалтад хийх буюу хагас хуримтлалын тогтолцоонд шилжих асуудлыг 2030-оноос хойш судлан үзэх;~~

3.2.14.2030 оноос эхлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийг хэсэгчлэн хагас хуримтлалын тогтолцоонд, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх;

3.2.15. тэтгэврийн даатгалын шимтгэл тооцох, тэтгэвэр тогтооход баримтлах цалин хөлс, орлогын доод, дээд хэмжээг Заегийн газрын журмаар зохицуулах Засгийн газар тогтоох;

3.2.16. тэтгэврийн хэмжээг жил бүрийн үнийн өсөлт болон дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж байх;

3.2.17. эдийн засаг, санхүү, хөрөнгийн зах зээлийн урьдчилсан нөхцөл хангагдсан тохиолдолд иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн хэвшлийн тэтгэврийн нэмэлт даатгалд хувиараа болон ажил өягөгчийнхөө олгогчийн дэмжлэгтэйгээр даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах;

~~3.2.18. хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг хувийн хэвшлийн тэтгэврийн сан эрхлэн гүйцэтгэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хөрөө эдгээр сангуудад тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;~~

3.2.18. хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг хувийн хэвшлийн тэтгэврийн сан ба уг сан бүхий хувийн хэвшлийн урт хугацааны даатгалын компани эрхлэн гүйцэтгэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хөрөө эрх бүхий байгууллага эдгээр сангуудад санд тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

3.2.19. даатгуулагчийн хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд төлөх шимтгэл, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлыг хуулиар зохицуулах;

3.2.20. хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоо нь бүрэн хуримтлалын байх бөгөөд даатгуулагчийн тэтгэврийн хэмжээ түүний төлсөн шимтгэл, хөрөнгө оруулалтад хийсэн оруулалтын өгөөжөөс хамаарах;

3.2.21. хувийн **хэвшлийн** тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын

багцыг хянах, хөрөнгө оруулалтын эрсдлийг зохицуулах, хөрөнгө оруулалтын өгөөжийг ~~жувь~~ хүний **даатгуулагчийн** дансанд шилжүүлэх асуудлыг хуулиар зохицуулах;

~~3.2.22.1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн зардал, цэргийн алба хаасны тэтгэврийн зардал, тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг улсын төсвөөс санхүүжүүлэх.~~

3.2.22.цэргийн алба хаасны, нийгмийн халамжийн, 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн иргэний тэтгэврийн зардал болон тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг улсын төсвөөс санхүүжүүлэх.

3.3.Малчид Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эрхлэгчийн тэтгэврийн даатгалын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1.малчид малчин, бага орлоготой хувиараа хөдөлмөр эрхлэгчид эрхлэгч, албан бус хөдөлмөр эрхлэгчид зориулсан тэтгэврийн даатгалын тусгай сан байгуулж, шимтгэлийн хэмжээ, хугацаа, тэтгэврийн нас болон тэтгэвэр тогтоох, олгох харилцааг тусгай хуулиар зохицуулах;

3.3.2.малчид малчин, бага орлоготой хувиараа хөдөлмөр эрхлэгчид эрхлэгч, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50-иас багагүй хувийг төрөөс хариуцах **бөгөөд төрөөс тэтгэврийн даатгалын шимтгэлийг хариуцах хугацааг хуулиар зохицуулах;**

3.3.3.тэтгэврийн хэмжээг тэтгэвэр бодох аргачлал нь энгийн, ойлгомжтой, даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаанаас тэтгэврийн хэмжээ нь хамаарахаар байх;

3.3.4.нийгмийн даатгалын байгууллага нь тусгай санд шимтгэл цуглуулах үйл ажиллагааг эрхэлж, даатгуулагчийн өөрөө төлсөн шимтгэл болон төрөөс хариуцан төлсөн шимтгэлийг тухай бүр бүртгэж, даатгуулагчид мэдээлэх;

3.3.5.тусгай сангийн хуримтлагдсан хөрөнгийг өсгөн арвижуулах зорилгоор Засгийн газрын бонд, үнэт цаас, бусад эрсдэл багатай банк, санхүү, хөрөнгийн зах зээлийн хэрэгслүүдэд зээлд хөрөнгө оруулалтад оруулалт хийх.

3.4.Тэтгэврийн нас, тэтгэвэр тогтоох хөнгөлөлттэй нөхцөлийн тухайд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

~~3.4.1.хүн амын насжилттай уялдуулан эмэгтэйчүүдийн тэтгэвэр тогтоолгох насыг 2017 оноос шат дараатай нэмэгдүүлэх зарчмаар 2027 онд 60 насанд, харин эрэгтэйчүүдийн тэтгэвэр тогтоолгох насыг 2027 онд 62 насанд тус тус хүргэх;~~

3.4.1.хүн амын дундаж насжилттай уялдуулж, тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаарыг өөрчлөх асуудлыг судлах;

~~3.4.2.тэтгэвэр тогтоолгох насны хязгаарыг ижил түвшинд хүргэх асуудлыг тухайн үеийн хүн амын насжилтын уялдуулан 2030 оноос хойш судалж үзэх;~~

~~3.4.3.хүүхэд төрүүлж, хуульд заасан нас хүртэлх хугацаанд асарсан эхчүүдийн хүүхдээ асарсан хугацааг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласнаар тооцож, даатгалын сангаас олгох жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн хугацааг нэмэгдүүлнэ. Дөрөв ба түүнээс дээш хүүхэд төрүүлж, өсгөсөн эхчүүдийн тэтгэврийн насыг 2017-оноос аажмаар нэмэгдүүлж, 2027 онд 55 насанд, цаашид 60 насанд хүргэх;~~

3.4.2.хүүхэд төрүүлж, хуульд заасан нас хүртэлх хугацаанд асарсан эхчүүдийн хүүхдээ асарсан хугацааг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласнаар тооцон нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн хугацааг нэмэгдүүлэх;

3.4.3.хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл /газрын дор болон хортой, халуун/-д ажиллагчдын хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоолгосон тэтгэврийн зардлыг тэтгэврийн ердийн нас хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас хариуцах;

3.4.4.хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэврийн ердийн наснаас өмнө тэтгэвэр тогтоох нас, ажилласан жилийн шалгуур болзлыг шинэчилж, хуулиар зохицуулах.

3.5.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тухайд талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

~~3.5.1.тэтгэврийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, ахмад настны тэтгэврийг бууруулахгүй байх үүднээс тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 2017-оноос 18-19 хувьд хүргэж, үүнээс ажил-өлгөгч 9-10,0 хувийг, даатгуулагч 9,0 хувийг төлөх;~~

3.5.1.ахмад настны тэтгэврийн үнэлэмжийг сайжруулах, ирээдүйн ахмад настны тэтгэврийн хувь хэмжээг бууруулахгүй байх үүднээс тэтгэврийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах, эдийн заегийн санхүүгийн үр ашигтай бөлгөх бодлого баримтлах;

3.5.2.малчид малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид эрхлэгч, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг хуулиар зохицуулах;

3.5.3.тэтгэврийн даатгалын шимтгэл ногдуулах, тэтгэвэр тооцох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын доод, дээд хязгаарыг улсын дундаж цалин хөлсний хэмжээтэй уялдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтоох;

3.5.4.хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч болон даатгуулагчийн харилцан тохиролцсон гэрээгээр зохицуулах.

3.6.Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.6.1. нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь босоо удирдлагатай, улсын хэмжээний бүтэцтэй байх;

3.6.2. аж ахуйн нэгж, байгууллага даатгуулагчийн тооноос хамаарч орон тооны ба орон тооны бус нийгмийн даатгалын ажилтантай байх;

3.6.3. ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийг бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх, нууцлалыг хадгалах үйл ажиллагааг мэдээллийн дэвшилтэт технологи ашиглан гүйцэтгэх мэдээлэл, сургалтын төвийг нийгмийн даатгалын төв байгууллагын харьяанд шинэчлэн зохион байгуулах;

3.6.4. ажил олгогч, даатгуулагч хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд шимтгэл төлөх тохиолдолд шимтгэлээ нийгмийн даатгалын байгууллагаар дамжуулан хувийн тэтгэврийн даатгалын өангуудад санд шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.6.5. нийгмийн даатгалын байгууллагын соёлыг нэвтрүүлж **хөгжүүлэх**, удирдлагын нээлттэй, ил тод үйл ажиллагааг төлөвшүүлэн төсөв, санхүүгийн хариуцлага, дотоод хяналтыг сайжруулах;

3.6.6. нийгмийн даатгалын ажилтныг чадавхижуулах, давтан бэлтгэх, мэргэшүүлэх, тасралтгүй сургах сургалтын нэгдсэн тогтолцоотой болох;

3.6.7. хууль тогтоомжийн биелэлт, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад хяналт тавих, нийгмийн даатгалын үйл ажиллагаа, тайлан мэдээллийг хэлэлцэж, зөвлөмж гаргах үүрэг бүхий Засгийн газар, даатгуулагч, ажил олгогчийг тэнцүү тоогоор төлөөлсөн зөвлөл байгуулж ажиллах.

ТАВ.ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ҮЕ ШАТ, ХҮРЭХ ҮР ДҮН

Дөрөв.Тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн

4.1. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг ~~хэрэгжүүлэх арга зам~~ дараах арга замаар хэрэгжүүлнэ:

4.1.1. тэтгэврийн даатгалын хууль, эрх зүйн баримт бичиг, стратеги төлөвлөгөө, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэхэд энэхүү бодлогыг эш үндэс болгож, шаардагдах хөрөнгийг улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

4.1.2. Засгийн газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, жөлбөгдөж агентлаг **нийгмийн даатгалын төв байгууллага** болон **нийгмийн** даатгалын харилцаанд оролцогч талууд тал, аж ахуйн нэгж **ажил олгогч**, байгууллага Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөө батлан биелэлтийг зохион байгуулах;

4.1.3. Засгийн газар үйл ~~ажиллагааныхаа~~ ажиллагааны хөтөлбөрт

тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүнд хяналт шинжилгээ хийж ~~ажиллана~~ ажиллах;

4.1.4. хүн амын ~~наежилтийн үзэгдэл~~ насжилт, эдийн засаг, санхүүгийн хямралаа ~~нөхцөл байдлаас~~ шалтгаалан зайлшгүй тохиолдож болзошгүй тэтгэврийн даатгалын сангийн ирээдүйн алдагдал, нэрийн дансны тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд шилжих тохиолдолд шаардагдах шилжилтийн зардлыг тус тус санхүүжүүлэх зорилгоор тэтгэврийн нөөц сан ~~байгуулж бөлнө~~ байгуулах.

4.2. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

4.2.1. нийгмийн даатгалын багц жуулийн тухай хууль тогтоомжийн төслийг шинэчлэн боловсруулж, ~~унх аар~~ Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулна батлуулах ~~жөлбөгдөх дүрэм, журмуудыг шинэчлэн батлуулна~~ /2015-2016 он/;

4.2.2. тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх асуудлаар олон нийтэд чиглэсэн, мэдээлэл сурталчилгаа хийх замаар нийгэм дэх ойлголтыг сайжруулж, нийгмийн харилцан ойлголцол, зөвшилцөл, түншлэлийг бэхжүүлнэ бэхжүүлэх /2017-2020 он/;

4.2.3. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах эхний үе шатны бодлогыг хэрэгжүүлнэ хэрэгжүүлэх /2017-2022 он/;

4.2.4. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны хэрэгжилтийн үр дүнг үнэлж, хоёр дахь шатны бодлогыг хэрэгжүүлнэ хэрэгжүүлэх /2023-2030 он/.

4.3. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлснээр ~~гарах үр дүн~~ дараах үр дүнд хүрнэ:

4.3.1. даатгуулагч төлсөн шимтгэлтэйгээ уялдаатай ~~эхиетэй~~ хэмжээний тэтгэвэр авах олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бий болгох;

4.3.2. тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг дунд болон урт хугацаанд бууруулснаар улсын төсвийн ачаалал багасч, ~~төр хөрөөр иргэд~~ иргэн, аж ахуйн нэгжид татварын дарамт үүсэхгүй байх;

4.3.3. тэтгэврийн даатгалын хамрах хүрээ нэмэгдэж, ахмад настан бүр наад захын орлогын баталгаагаар хангагдах;

4.3.4. хүн амын насжилттай уялдуулан тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд ~~шаардлагатай~~ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хууль эрх зүйн орчинг цогцоор нь шинэчлэх эрх зүйн үндэс бий болох;

4.3.5. малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч тэтгэврийн ~~даатгалтай бөлж~~ даатгалд хамрагдаж, ирээдүйн нийгмийн баталгаа нь сайжрах;

4.3.6. өндөр орлоготой ажиллагчдад **даатгуулагчид** зориулсан хувийн жөвшлийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоо бий бөлж **бүрдэж**, ахмад настан олон эх үүсвэрээ **бүхий** тэтгэврийн орлоготой байх нөхцөл **бүрдөнө хангагдах**;

4.3.7. тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны шинэчлэлийг эрчимжүүлж, 1960 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн хэмжээ өгцөм тэтгэвэр буурахгүй бөлнө байх;

4.3.8. тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн технологи, удирдлага, байгууллагын бүтэц, чадавхийг чадавх бий бөлнө болох;

4.3.9. тэтгэврийн шинэчлэлийн асуудлаар нийгэм дэх ойлголтыг сайжруулж, нийгмийн харилцан ойлголцол, зөвшилцөл, түншлэл бэжинэ бэхжих.

-oOo-